

**BUILDING
BETTER
FUTURE**



МОНЦЕМЕНТ

БАТ БЭХ ХӨГЖЛИЙН СУУРЬ



Эрхэм зорилго

Үйлчилгээний соёлоор тэргүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартыг олон улсын түвшинд чанарыг тасралтгүй хөгжүүлж барилгын салбарын насжилтыг нэмэгдүүлнэ.



Үнэт зүйлс

- Чанар технологи
- Манлайлал
- Хамт олон
- Аюулгүй үйл ажиллагаа



Алсын хараа

Чанараар манлайлж, хөгжлөөр түүчээлнэ.

Танилцуулга

“МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК нь Монполимет Групп болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны (EBRD) хөрөнгө оруулалт, дэмжлэгтэйгээр **Монгол Улсын** Барилгын материал үйлдвэрлэл, нийлүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар Дорноговь аймгийн Өргөн суманд 2015 онд Дэлхийн хамгийн орчин үеийн **дэвшилтэт** арга, техник, технологиудыг нэвтрүүлэн жилд нэг сая тонн өндөр чанарын цемент үйлдвэрлэх **хуурай аргын** цогц үйлдвэрийг барьж байгуулан ажиллаж байна.



Монгол Улсын барилгын материал үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн энэ **жишиг** бүтээн байгуулалт нь түүхий эдийн зүй зохистой ашиглалт, тээвэр логистикийн зөв шийдэл, байгаль орчны ээлтэй үйл ажиллагаа, техник, технологийн

дэвшил **ноу-хауг** өөртөө шингээсэн цогц шийдэл болж байгаагаараа онцлог төдийгүй улсдаа анхдагч **ЭКО үйлдвэр** юм.





Өргөн үйлдвэр

Дорноговь аймгийн **Өргөн** суманд байрлах шохойн чулууны ил уурхай, цемент үйлдвэрлэх иж бүрэн 2 шугам, технологийн явцаас гарах **хаягдал дулааныг** дахин боловсруулж цахилгаан **эрчим хүч** үйлдвэрлэх **WHR систем** зэргээс бүрдэнэ.

Тус цогц үйлдвэр нь жилд **1 сая тонн** өндөр чанарын цемент үйлдвэрлэх хүчин чадалтай.

Монцемент Улаанбаатар үйлдвэр

Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ ойртуулах, тэдгээрт хурдан шуурхай хүргэх логистикийн асуудлуудыг хялбаршуулах үүднээс үйлдвэрийн нэг хэсгийг **Улаанбаатар** хотын нутаг дэвсгэрт барьж байгуулан Олон улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан цементийг зах зээлд нийлүүлж байна.

- Клинкер вагоноос буулгах, хуваарилах иж бүрэн систем
- Цементийн 2 тээрэм
- 26,000 тонн багтаамжтай түүхий эдийн агуулах
- 12,000 тонн цемент агуулах Улаанбаатар хотын хамгийн том 4 силос
- Задгай болон савласан цемент машинд зэрэг ачих боломжтой автомат систем
- Удирдлага - хяналтын төв, Чанарын лаборатори
- Төмөр зам авто замаар түүхий эд хүлээн авч ангилан тэжээх 200 тн/ц бутлуурын цогц систем

Монполимет Групп

Монполимет групп нь Монгол улсын тэргүүний аж ахуйн нэгж, манлай компани болон өргөжин хөгжсөөр ирлээ. Манай групп өөрийн үйл ажиллагаандаа байгаль орчинд ээлтэй технологиудыг нэвтрүүлж Монгол Улсын Засгийн газраас **“Шилдэг Нөхөн сэргээгч Аж Ахуйн Нэгж”** байгууллагаар жил болгон тасралтгүй **21 удаа** шалгарсан нь

манай хамт олны үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, нийгмийн хариуцлага эх орондоо оруулж буй хувь нэмрийг үнэлж буй хэрэг юм. Бид уул уурхайн олборлолт, байгаль орчны нөхөн сэргээлт, барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэл, эрүүл мэнд, фитнесийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.



Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк нь (EBRD) нь барилгын материал үйлдвэрлэлийн салбарт байгаль орчин нийгэмд ээлтэй, тогтвортой хөгжлийг зорилгоо болгосон 65 улсын хамтын эзэмшил бүхий олон улсын санхүүгийн байгууллага юм. Дэлхийд 400 гаруй цементийн үйлдвэр барьж байгуулах төслийг амжилттай санхүүжүүлж хэрэгжүүлсэн арвин их туршлагатай. EBRD нь өөрийн санхүүжүүлж дэмжин ажиллаж байгаа төслүүдэд олон улсын жишиг болсон маш өндөр шалгуур тавьж ажилладаг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллага юм.

Ногоон технологи - WHR

Монцемент Билдинг Материалс ХХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн байгаль орчинд ээлтэй, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж ирсэн бөгөөд клинкер боловсруулах шугамтай зэрэгцээд хаягдал хийг ашиглан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх **WHRPG (Waste heat recovery power generation)** үйлдвэрийг Монгол улсдаа анх удаа барьж байгуулан ашиглаж байна. Тус систем нь Урьдчилан халаагч болон клинкерийн хөргүүрээс гарах **350-450C** хэмтэй хаягдал дулааныг эрчим хүч болгон хувиргах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн **Ренкайн Циклийг** ашигладаг технологи юм.



Агаарт цацагдах хүлэмжийн хийн хэмжээг бууруулна.



Төсвийн эрчим хүчний системээс хэрэглэх эрчим хүчний хэмжээг 20-40% - иар багасгана.



Нэгж бүтээгдэхүүний өртгийг бууруулж эдийн засаг, экологийн эерэг үр дүнтэй.



Үйлдвэрийн ашигт үйлийн коэффициент нэмэгдэнэ.



Хуурай аргын ЭКО технологи



Ус цэвэршүүлэх систем



Эргэлтийн усны
90%-ийг боловсруулан
дахин ашиглах ус
цэвэршүүлэх нэгдсэн
систем

Усны хэрэглээ нойтон
аргын технологиос 5
дахин бага



Газ анализер систем



Тоос ялгаралтыг 24
цагийн турш тасралтгүй
хянах агаарын хяналтын
систем

Тоос ялгаралтын хэмжээ
30мг/Нм3 - ээс бага



Эрчим хүчний зарцуулалт ба хяналт



Нэгж бүтээгдэхүүн
үйлдвэрлэхэд
зарцуулагдах эрчим
хүч МУ-д хамгийн
бага 80кВт/тн /Цемент
үйлдвэрлэлийн дэлхийн
жишигт 80-100кВт/тн/

АЧАА ӨРГӨХ
ТАЛБАЙ

Стандарт

Бид олон улсын чанарын стандартыг бүтээгдэхүүн, үйл ажиллагаандаа тогтмол ханган ажилладаг бөгөөд “MNS/ISO 9001:2015, MNS/ISO 45001:2018, MNS/ISO 17025:2018” “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” - уудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Мөн Монгол улсын MNS

стандартуудыг мөрдөхөөс гадна анхлан Европын EN стандартын шаардлагад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, чанарын хяналт, шинжилгээ бүтээгдэхүүн баталгаажуулах үйл ажиллагаа стандартын дагуу явагддаг болохыг баталгаажуулсан юм.



FLSmidth

Бид Дани улсын FLSmidth евро стандарт бүхий бүрэн автоматжуулсан тоног төхөөрөмж, технологийг ашиглахаас гадна дэлхийн тэргүүлэх SIEMENS, ABB, Schneider, Atlas Copco зэрэг брэндүүдийн орчин үеийн техник, технологи, хэрэгслийг ашиглан үйлдвэрлэлээ явуулж байна.



Магадлан итгэмжлэгдсэн Лаборатори

- Монцемент лаборатори нь Үндэсний итгэмжлэлийн төвөөр итгэмжлэгдсэн
- Олон улсын стандартаар баталгаажсан
- Орчин үеийн дэвшилтэт бүрэн автоматажсан техник технологи, тоног төхөөрөмжүүд
- Лабораторийн менежментийн онлайн системтэй



Эрдэст нэмэлт
10%



Нунтаглал
R008%<3



Хувийн гадаргуу
S CM/ GP > 3200



Тоос ялгаруулалт,
NO, SO-н хэмжээ
30 МГ/НМ-аас бага



Түлш зарцуулалт
нойтон аргаас
2 дахин бага

ХЭМАБ - Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа

Монцемент Билдинг Материалс ХХК нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын олон улсын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг бий болгох ажлын хүрээнд:



VFL - Удирдах ажилтны манлайллын хөтөлбөрийг бий болгож ажлын байрны эрсдэлийг тасралтгүй бууруулан ажилладаг.



Toolbox meeting - Өдөр бүр ажилтнууд ажилд гарахын өмнө ажлын байранд учирч болох аливаа эрсдэлүүдийг тодорхойлох замаар урьдчилан сэргийлэн ажилладаг.



RCA - Хөдөлмөрийн чадвар алдагдах эрсдэлийг багасгах зорилгоор (ХЧТА) эрсдэлийн үнэлгээг тогтмол хийхийн зэрэгцээ осолд дөхсөн тохиолдлуудын судлан бүртгэж учир шалтгааны шинжилгээг тогтмол хийж осолд хүргэж болохуйц эрсдэлийг арилгах системийг хэрэгжүүлдэг.



Safety patrol - Ажилтан бүр safety patrol хийж үйлдвэрийн онцлог, техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, ажлын байранд учирч болох эрсдэлүүдийн талаар мэдлэг, мэдээллээ хуваалцан ажлын байрны эрсдэлийг бууруулахад ажилтан бүр оролцдог.



Хүний нөөц

Манай компани ажилчдынхаа хувь хүний хөгжил болон ур чадварыг дээшлүүлэх зорилготойгоор сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажилладаг.

- Олон улсын мэргэжилтнүүдийн арга зүй
- Бусдын хүндэтгэх, хүйсийн эрх тэгш байдлыг хангахад онцгой анхаарч байна.
- Мэргэшсэн, чадварлаг, бүтээмжтэй хамт олноос суралцах
- Бие болон оюуны эрүүл мэндийг дэмждэг (төрөл бүрийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр)
- Эрүүл, аюулгүйн стандарт хангасан орчин нөхцөлөөр хангасан.



Хувь хүний хөгжил

Мэргэжлийн сургалт, хувь хүний хөгжил, ур чадвар дээшлүүлэх сургалт хөтөлбөрүүд



Үйлдлээр манлайлах

- Хамт олон /Ёс зүй, зөв хандлага, хүсэл эрмэлзэлтэй/
- Карьерын боломж /Албан тушаалын хувьд өсөж хөгжих, туршлага хуримтлуулах/
- Ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамааран урамшуулал нэмэлт боломж
- Аюулгүй үйл ажиллагаа

APPLICATION

Бид цемент үйлдвэрлэлтийн салбартаа анхлан онлайн захиалгын системийг бий болгосон бөгөөд хэрэглэгч та бүхний хэрэгцээ шаардлагад тулгуурлан түргэн шуурхай хүрч үйлчлэхийн тулд хоногийн 24 цаг тасралтгүй хүргэлт гаргах үйлчилгээ буюу Монцемент апп-ыг нэвтрүүлсэн юм.



Хүргэлтийг GPS -р хянах боломжтой



Захиалгын процесс хурдан



Хэрэглэгчдэд илүү ойр




24/7 үйл ажиллагаатай

Бүтээгдэхүүнүүд

Бүх салбар

Улаанбаатар

Өргөн



Бүтээгдэхүүн



Эзлэхүүний өөрчлөлт байхгүй



28 хоногийн дараах бат бэх өндөр



28 хоногийн дараах гулзайлтын бат бэх - 7,8 МПа



Усны хэрэглээ нойтон аргын технологиос 5 дахин бага



Эрчим хүчний зарцуулалт нойтон аргаас 30%-р бага



OPC 42.5

Өргөн хэрэглээний OPC 42.5 цемент нь бүх төрлийн барилга угсралт болон зам гүүрний ажил, бетон эдлэлийн үйлдвэрлэлд ашигладаг.

Бат бэхийн ангилал нь 42.5 МПа (400 кг/см²)



CPC 32.5

Өрхийн хэрэглээний CPC 32.5 цемент нь зуслангийн байшин, бага маркийн бетон цутгалт, дотор засал, замын бүтээцийн суурь ажилд бүрэн нийцсэн юм.



PC 52.5

Өндөр бат бэх бүхий угсармал хийц, урьдчилан хүчигтэсэн бүтээц, төмөр замын бетон дэр, харьцангуй өндөр ачаалалд ажиллах төмөр бетон цутгамал байгууламж, өндөр хүчдэлийн шон, зам гүүр зэрэгт хэрэглэгдэнэ.

Энэхүү цементийн бат бэх нь 52.5 МПа (600 кг/см²)

Тээвэр - логистик



Монгол Улсын төмөр замын сүлжээнд холбогдсон өөрийн эзэмшлийн 3,5 км салбар төмөр замтай.



Орчин үеийн өндөр даацын 40 хоппер вагон, 50 хагас вагон болон ТЭМ18ДМ серийн сэлгээний зүтгүүр бүхий өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнтэй.



GPS системээр хянах боломжтой, УБ хот болон орон нутагт задгай цементийн 24/7 хүргэлт.

Борлуулалтын цэгүүд:



Хамтарсан төслүүд:



Тавантолгой-
Зүүнбаян чиглэлийн
төмөр зам
2021 он



Олимпын гүүр
2020 он

Ус гүн
цэвэршүүлэх
үйлдвэрийн
төсөл 2024 он





Дархан
-Улаанбаатар
чиглэлийн босоо
тэнхлэгийн 204,6
км авто зам



Яармагийн шинэ
гүүр 2024 он

Дэлгэрэх сумын
шинэ гүүр



Таван толгой
Ханги чиглэлийн
477км хүнд
даацын авто зам
барих төсөл



Улаанбаатар
хотын төв
цэвэрлэх
байгууламжийг
барих төсөл



Замын-Үүд
боомтын шинэчлэл
2024 он

Газрын тос
боловсруулах
үйлдвэр
2020-2024он



Оюутолгойн
Гүний уурхайн
бүтээн
байгуулалт
2018 он





Улаанбаатар хот, СХД, 1-р хороо,
МПМ барилга 15 давхар



976+ 75951133



www.moncement.mn